



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/550

Булган сум

Журам, болзол дүгнэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.6, 4.1, аймгийн Засаг даргын "Журам шинэчлэх тухай" 2022 оны А/435 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан, тогтвортой амжилт гаргасан дараах малчдыг "Аймгийн аварга малчин өрх"-өөр шалгаруулсугай. Үүнд:

Бүрэгхангай сумын Бумбат багийн малчин Л.Мөнхбаатар, эхнэр М.Энхтуяа

Бүрэгхангай сумын Бумбат багийн малчин Д.Зоригт

Бүрэгхангай сумын Цахт багийн малчин Г.Гантулга, эхнэр Ж.Тэрбиш

Бүрэгхангай сумын Цахт багийн малчин А.Загд, эхнэр Д.Батжаргал

Хишиг-Өндөр сумын Банзар багийн малчин Т.Сэргэлэн, эхнэр Б.Энэбиш

Хишиг-Өндөр сумын Хүрэмт багийн малчин Ч.Ганболд, эхнэр О.Энхбаяр

Хишиг-Өндөр сумын Тээг багийн малчин А.Энхбат, эхнэр Х.Энхцэцэг

Хишиг-Өндөр сумын Жаргалант багийн малчин Х.Бат-Эрдэнэ, эхнэр

Х.Болормаа

2. Дээрх шагналын зардлын тооцоог хавсралтаар баталж, шаардагдах нийт 6,400,000 (зургаан сая дөрвөн зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010589